

**“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 сарын 30-ны өдөр

№4

Өлгий хот

Ээлжит хурлыг 10.00 цагаас “MJS Tower” -ийн 5 давхарын компанийн оффисанд хуралдуулж ТУЗ-ийн дарга А.Манен удирдав.

Хуралд хувьцаа эзэмшигч Д. Мурат, ТУЗ-ийн гишүүд А.Бейбит, А.Мубарак, Х.Ертай, Е.Жанболат, М.Тилеуберди, Ц.Баттөмөр, У.Харашаш, О. Адалбек нар оролцов.

Коронавирус цар тахлаас сэргийлж амны хаалт зүүж, ТУЗ – ын гишүүд тус бүр 1м – ийн хол зайтай сууж хурлаа хийхээр сандал, ширээнүүдийг хувиарлаж сууцгаав.

Хурлын тооллогын комиссын мэдээллийг комиссын дарга О.Адилбек танилцуулав. /Мэдээллийг хавсаргав/

Хуралд компанийн дүрмийн дагуу 7.4 дэх хэсэгт заасны дагуу нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 89,5% оролцож байгаа тул хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Эрчимбаян Өлгий (ХК) компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

А.Манен: Компанийн ТУЗ – ийн 2021 оны 03 сарын 21 – ний өдрийн 03 - р хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталсан. Энэ төлөвлөгөөний дагуу эхний асуудал болох “Эрчимбаян Өлгий” ХК – ны 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ – ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлыг хэлэлцэе. Холбогдох зарим хүмүүст танилцуулга хийе. Компанийн 2020 үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх ТУЗ – ийн дүгнэлтийг ТУЗ – ийн гишүүн У. Харашаш танилцуулав. /2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ – ийн дүгнэлтийг хавсаргав./

Хуралд оролцогчид саналаа хэлэв.

Д. Мурат: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх ТУЗ -ийн дүгнэлтийг харлаа. Санхүүгийн тайлангийн аудитийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Акбар аудит” ХХК – иар хийлгэж, баталгаажуулсан

байна. Компанийн санхүүгийн тайлангуудаас харахад авлага өнгөрсөн жилээс их байна. Энэ юутай холбоотой вэ?

К. Ерболат: 20 гаруй байгууллагын төсвийг орон нутгаас баталдаг. Бусад байгууллагуудын төсөв улсын төсвөөс баталдаг. 2020 оны Орон нутгаас баталсан төсвөөс 149 сая төгрөг дутуу батлагдсанаас болж авлага үүссэн. Одоо нөгөөтэйгүүр Коронавирус цар тахалтай холбоотой ЗГ – аас ААН болон Орон сууцны төлбөрийг төрөөс даахаар шийдвэрлэсэнээс болж ДҮТ – ээс 172 сая төгрөгийн авлага зэрэг үүссэн.

Д. Мурат: Компани үйл ажиллагааны шаардлагын хэмжээнд сайн гүйцэтгэж явуулсан байна. ТУЗ – ийн дүгнэлтийг дэмжинэ.

А. Бейбит: Манай компани улсаас ямар ч санхүүгийн дэмжлэг авдаггүй. Өнгөрсөн онд дулаан дамжуулах төвүүдийг засварласан. Мөн 4 – р зуухыг ашиглалтанд оруулсан. 4 – р зуухны материалуудыг БНХАУ болон ОХУ – аас захиалж авхуулсан. Эдгээр бүх ажлуудыг өөрийн хөрөнгөөр хийх боломжгүй тул банкнаас өндөр хүүтэй зээл авсан. Үүнээс болоод компанийн ашиг бага гарч байна. 2020 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдсан.

М. Тилеуберди: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ – ийн дүгнэлттэй бүрэн танилцлаа.

Дүгнэлт үндэслэлтэй зөв хийгдсэн байна. Өнгөрсөн онд хийсэн засвар, шинэчлэлийн ажлууд их хийгдсэн. Авлагын талаар сая ерөнхий нягтлан бодогч К. Ерболат тодорхой ярьлаа. Бид энэ асуудлаар холбогдох газарт зөндөө ярьж, асуудал тавьж ажиллаж байна. Гэвч үр дүн гарахгүй хэвээр байна.

ТУЗ – ийн дүгнэлтийг дэмжиж байна.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100% дэмжив.

Дараа нь ТУЗ – ийн дарга А. Манен хурлаас гаргах тогтоолын төслийг танилцуулж саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг тодруулахад төсөлтэй холбоотой санал гараагүй. Тогтоолын төслийг батлах асуудлаар илээр санал хураахад хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100% хувь дэмжив.

Шийдвэрлэсэн: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ – ийн дүгнэлтийг санал нэгтэй батлах.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

2. Эрчимбаян Өлгий (ХК) компанийн 2020 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн компанийн аудиторын дүгнэлтийг танилцуулах;

А. Манен: Одоо аудитийн тайлангийн талаар хэлэлцье. Энэ талаар ерөнхий нягтлан бодогч К. Ерболат танилцуулья.

К. Ерболат: Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсан “Акбар аудит” ХХК – ийн аудитийн тайланг уншиж танилцуулав. /Аудитийн дүгнэлтийг хавсаргав./

Д. Мурат: Аудитийн тайлан бодитой зөв хийгдсэн байна. Аудит хийсэн компаниас орлого, үр дүнгийн тайланд удирдлагын бодит борлуулалтын үйл ажиллагааны зардлыг ерөнхий ба удирдлагын зардалд тусгаж харуулах зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн байна. зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт даалгая.

М. Тилеуберди: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Ц. Баттөмөр: Аудитийн дүгнэлт үнэн зөв хийгдсэн байна. Залуу удирдагч гүйцэтгэх захирал маань идэвхи санаачлагатай ажиллаж байна.

Хуралд оролцогчдоос өөр санал гарсангүй. Хэлэлцэж байгаа асуудлын талаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж, саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100% дэмжсэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН: Компанийн 2020 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторийн тайланг баталж өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал М. Тилеуберди, ерөнхий нягтлан бодогч К. Ерболат нарт үүрэг болгох.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ: Ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ – ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.

А. Манен: Компанийн ТУЗ – ийн 2021 оны 02 сарын 16 – ний өдрийн 01 дүгээр хурлаар ногдол ашиг хувиарлах эсэх асуудлыг хэлэлцэн ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн. Хуульд зааснаар энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэх ёстой. Энэ талаар ТУЗ – ийн нарийн бичгийн дарга О. Адалбек танилцуулья.

О. Адалбек: Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 – д зааснаар

ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хонгийн дотор ногдол ашиг хувиарлах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх ёстой. Энэ асуудлыг ТУЗ – ийн 2021 оны 02 сарын 16 – ний өдрийн 02 дугаар хурлаар ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн. Учир нь 2020 оны жилийн эцсийн тайлангаар 26,065,071 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч нийт өглөг 1,179,104,361 төгрөгийн өглөгтэй, авлага 1,410,892,183 хүрч ногдол ашиг хувиарлах тухай Компанийн хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1 – д заасан шаардлагыг хангахгүй байна.

Д. Мурат: ТУЗ – ийн шийдвэрийн талаарх ТУЗ -ийн шийдвэрийг сонслоо. Дэмжиж байна. Зөв шийдвэр гаргасан байна.

М. Тилеуберди: Би ТУЗ -ийн хуралд оролцсон. Надад ямар нэгэн санал байхгүй.

Хэлэлцсэн асуудлаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100% дэмжсэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх ТУЗ – ийн шийдвэрийг санал нэгтэй дэмжиж батлах.

Хурлыг 12:10 цагт дуусав.

Хурал удирдсан: ТУЗ – ийн дарга

Тэмдэглэл хөтөлсөн:



А. Манен

Ж. Жулдыз